

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН
ТӨЛӨБЛӨГӨӨ**

2019.01.23

№02

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1	Аж ахуйн тооцоотой үлйдвэрийн газар байгуулах тухай	С.Байгальмаа	Л.Очир Б.Бямбадорж З.Цэндсүрэн	Тогтоол 04
2	Төрийн дээд шагналд өргөн мэдүүлэх тухай	Б.Алтайбаатар	Б.Ичинхорол	Тогтоол 05
3	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай	А.Амарзаяа	Л.Батжаргал	Тэмдэглэл
4	Аймгийн аварга тэмээчин шалгаруулж, шагнах тухай /Тэмээн сүрэг өсгөх болзол хангасан/	С.Байгальмаа	С.Гансэлэм С.Эрдэнэ-Очир	Тогтоол 06
5	Аймгийн аварга үхэрчин шалгаруулж, шагнах тухай /Үхэр сүрэг өсгөх болзол хангасан/	С.Байгальмаа	С.Гансэлэм С.Эрдэнэ-Очир	Тогтоол 07
6	Аймгийн Тэргүүний хоршоо шалгаруулж, шагнах тухай	С.Байгальмаа	С.Гансэлэм П.Мөнхзаяа	Тогтоол 08
7	Аймгийн Тэргүүний хамт олон шалгаруулж, шагнах тухай	С.Гансэлэм	Ч.Бат-Эрдэнэ Б.Алтайбаатар М.Эрдэнэбилэг	Тогтоол 09
8	Аймгийн Хөдөлмөрийн аваргууд шалгаруулж, шагнах тухай	С.Гансэлэм	Ч.Бат-Эрдэнэ Б.Алтайбаатар М.Эрдэнэбилэг	Тогтоол 10
9	Аймгийн аварга Уяач-Тэмээчин шалгаруулж, шагнах тухай	С.Гансэлэм	Ч.Бат-Эрдэнэ Б.Алтайбаатар М.Эрдэнэбилэг	Тогтоол 11



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 04

Есөнбулаг сум

Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн
газар байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "Ж", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Солонго хорооллын дулааны станц ашиглалтад орохтой холбогдуулан "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулсугай.

2. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааг жигдрүүлэн, хяналт тавьж, аймгийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын төлөөлөн удирдах зөвлөлтэй хамтран ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Ойнбилэг/ нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.БАТЖАРГАЛ

0000018



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 05

Есөнбулаг сум

Төрийн дээд шагналд өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:


1. Эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гарган, аймаг, сум орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж, хавсралтад дурдсан хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2. Төрийн дээд шагналд тодорхойлогдсон хүмүүсийн тодорхойлолт, материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба, нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Амарзаяа/-д даалгасугай.

ДАРГА  БАТЖАРГАЛ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 01 дүгээр сарын 21-ны
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт




№	Овог нэр, сум, одоо эрхэлж буй ажил	Өргөн мэдүүлэх шагнал
1.	Гэсэр Бүрэнчөдөр /Есөнбулаг сум, Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн эрхлэгч/	Гавьяат эмч
2.	Ухнаа Нямжав /Бугат сум, "Эрдэм-Эрдэнэ" сургалтын төвийн эрхлэгч/	Гавьяат багш
3.	Тумбаа Батсуурь /Тонхил сум, Тонхил сумын Соёлын төвийн эрхлэгч/	Соёлын гавьяат зүтгэлтэн
4.	Гүржав Хишигхүү /Есөнбулаг сум, Өндөр настан/	Аж үйлдвэрийн гавьяат ажилтан
5.	Цог Жүгдэр /Дарив сум, Өндөр настан/	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
6.	Даш Хандхүү /Есөнбулаг сум, "Арвижих-Ундарга" хоршооны дарга/	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
7.	Галбадрах Намсрай /Есөнбулаг сум, "Арвин өргөө констракшн" ХХК-ны кранчин/	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
8.	Мөнхбаяр Банзаагааяа /Есөнбулаг сум, АШУУИС-ийн аймаг дахь АУС-ийн захирал/	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
9.	Цэмбэл Жүгдэрнамжил /Чандмань сум, Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал/	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
10.	Нүдэн Дагина /Цээл сум, Эрүүл мэндийн төвийн тогооч/	Алтангадас одон
11.	Ухнаа Батмөнх /Чандмань сум, Хүрхрээ багийн тариаланч/	Алтангадас одон
12.	Нямхүү Хишигмаа /Есөнбулаг сум, Ахмад багш нарын холбооны тэргүүлэгч/	Алтангадас одон
13.	Хорол Энхцэцэг /Есөнбулаг сум, 1-р сургуулийн монгол хэл, уран зохиолын багш/	Алтангадас одон
14.	Ходоод Сарангэрэл /Есөнбулаг сум, "Дэлгэрэх жимс" ХХК-ий захирал/	Алтангадас одон
15.	Сэндэн Оюунчимэг /Есөнбулаг сум, 2-р сургуулийн математикийн багш/	Алтангадас одон

16.	Жамба Нацагаа /Алтай сум, Ахмад настан/	Алтангадас одон
17.	Рэгзэн Санжжав /Есөнбулаг сум, Хувиараа эрхлэх аж ахуй/	Алтангадас одон
18.	Баянтөр Давааням /Есөнбулаг сум, Ахмад настан/	Алтангадас одон
19.	Баярчулуун Гүрбазар /Есөнбулаг сум, Холбооны газрын жолооч, нярав/	Алтангадас одон
20.	Дорж Шүхэр /Цээл сум, Ахмад настан/	Алтангадас одон
21.	Цэвээндорж Нямсүрэн /Есөнбулаг сум, "Нийтлэг үйлчилгээ" ОНТҮГ-ын үйлчлэгч/	Алтангадас одон
22.	Цогзол Алтантуяа /Есөнбулаг сум, Хувиараа эрхлэх аж ахуй/	Хөдөлмөрийн хүндэт медаль
23.	Содном Болормаа /Есөнбулаг сум, 1-р цэцэрлэгийн арга зүйч/	Хөдөлмөрийн хүндэт медаль
24.	Магван Цэвгээ /Есөнбулаг сум, 1-р цэцэрлэгийн багш/	Хөдөлмөрийн хүндэт медаль
25.	Далхжав Сувдаа /Есөнбулаг сум, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйлчлэгч, сахиул/	Хөдөлмөрийн хүндэт медаль
26.	Цэвэл Мөнхцэцэг /Есөнбулаг сум, "Оргил паб" хоолны газрын ахлах тогооч/	Хөдөлмөрийн хүндэт медаль
27.	Орсоо Нямсайхан /Чандмань сум, Малчин/	Хөдөлмөрийн хүндэт медаль
28.	Хайням Балжинням /Дарив сум, Өндөр настан/	Хөдөлмөрийн хүндэт медаль
29.	Доржхүү Ганзул /Баян-Уул сум, Сум дундын эмнэлгийн тогооч/	Хөдөлмөрийн хүндэт медаль
30.	Цэвээндорж Цэвэгмэд /Есөнбулаг сум, Улаан загалмайн хорооны зөвлөх/	Хөдөлмөрийн хүндэт медаль
31.	Чулуунхүү Дэמידмаа /Есөнбулаг сум, 2-р сургуулийн монгол хэл, уран зохиолын багш/	Хөдөлмөрийн хүндэт медаль
32.	Дамдинсүрэн Энхтуяа /Эрдэнэ сум, Эрдэнэ сумын сургуулийн тогооч/	Хөдөлмөрийн хүндэт медаль
33.	Жанчив Сайнбилэг /Есөнбулаг сум, 2-р цэцэрлэгийн багш/	Хөдөлмөрийн хүндэт медаль

34.	Удхүү Дархижав /Есөнбулаг сум, 1-р сургуулийн ахлах тогооч/	Хөдөлмөрийн хүндэт медаль
-----	---	---------------------------

___оОо___

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 11 дүгээр сарын 23-ны
өдрийн 04 дүгээр тогтоолын
хавсралт.



“СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ” АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь аймгийн “СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг мөн.

1.2. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хот суурин, ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Усны тухай хууль, Газрын тухай болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Энэхүү дүрмийн зорилго нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөн байгуулах, удирдлага, зохион байгуулалт, бүтэц, хяналт, газар, эд хөрөнгийн эрх түүнийг өөрчлөн байгуулах, бүртгэхтэй холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /орон нутгийн өмчийн оролцоотой компани/-ыг үүсгэн байгуулагч нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд өмчийн төлөөллийг Төлөөлөн Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

Хоёр. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хэлбэр, оноосон нэр, байршил

2.1. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй бие даасан тайлан тэнцэлтэй, ашгийн төлөө хуулийн этгээд байна.

Гурав. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын тэмдэг

3.1. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэл /эмблэм/-тэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

3.2. Тэмдэг нь “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.3. Тэмдгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг үйлдвэрийн газрын захирал хариуцна.

Дөрөв. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийн сан

4.1 Орон нутгийн өмчийн "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, бусад нөөцөөс бүрдэнэ. Үйлдвэрийн газрын хөрөнгө нь 100 хувь орон нутгийн өмчийн хөрөнгө байна.

4.2 "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагааны чиглэлийн дагуу эзэмшин, ашиглаж захиран зарцуулна.

4.3 Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж бэлдэх, шилжүүлэх, худалдах, хувьчлах тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох эрх зүйн актуудыг баримталж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.

Тав. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл

5.1 "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үндсэн зорилго нь холбогдох үйлчилгээний чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж харьяалах нутаг дэвсгэртээ үйлчилгээнийхээ хүрээг тэлж хэрэглэгчдийг норм, стандартын шаардлагад нийцсэн жигд найдвартай үйлчилгээгээр хангаж үр ашигтай ажиллах явдал юм.

5.2. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь холбогдох хууль тогтоомж болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүргийн хэмжээнд өөрийн үйлдвэрийн газрын чиглэл тус бүрээр үйл ажиллагааг явуулж, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлээр байнга тасралтгүй хангахын зэрэгцээ дотоодын хяналтыг хэрэгжүүлнэ.

5.3. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь үндсэн үйл ажиллагаанаас гадна улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагааг явуулж орлого ашгаа нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

Зургаа. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын удирдлага, зохион байгуулалт

6.1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын удирдах дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

6.2. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал эрхлэн явуулна.

6.3. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь Монгол улсын Хөдөлмөрийн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журамтай байна.

Долоо. Төлөөлөн удирдах зөвлөл

7.1. Аймгийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь хамтын удирдлагаар асуудлыг шийдвэрлэх зорилгоор 5-аас доошгүй гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба зөвлөлийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн аймгийн Засаг дарга томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн хурлаар хэлэлцэн гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

7.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

7.2.1. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох

7.2.2. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах.

7.2.3. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж гэрээг сунгах, цуцлах тухай саналыг аймгийн Засаг даргад гаргаж шийдвэрлүүлэх. Гүйцэтгэх захирлын цалин, шагнал, урамшуулал, хангамж, өмч хөрөнгийн захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох.

7.2.4. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулах. Үйлдвэрийн газрын жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах

7.2.5. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах

7.2.6. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, хөрөнгийг данснаас хасах, шилжүүлэх, худалдах саналыг гаргаж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдэд уламжлах.

7.2.7. Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааны журам өөрийн үйл ажиллагааны зардалтай байна

7.2.8. Бусад асуудал

7.3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоол нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж тамга тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

7.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

7.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсны дагуу аль нэг гишүүн гүйцэтгэнэ

7.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг Компанийн тухай хуульд заасны дагуу хуралдуулна.

7.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг ТУЗ-ийн хурлаар гишүүдээсээ нэр дэвшүүлэн томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх үүргийг удирдах зөвлөлийн ажиллах журамд тусгана.

Найм. Гүйцэтгэх удирдлага

8.1. Гүйцэтгэх удирдлага нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

8.2. Гүйцэтгэх захирлыг ТУЗ-аас санал болгосноор аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө. Захирлаар сонгогдох этгээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

8.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

8.4. Гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, үйлдвэрийн газрыг төлөөлөх зэргээр үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

8.5. Гүйцэтгэх захирал нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын ерөнхий инженер, эдийн засагч, ерөнхий нягтлан бодогч нарыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг ТУЗ-тай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

8.6. Гүйцэтгэх захирал нь хувийн эрх ашгийн үүднээс үйлдвэрийн газрын нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхийг хориглоно.

8.7. Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг ТУЗ хэдийд ч гаргаж болно.

8.8. Гүйцэтгэх захирал нь хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж өгнө.

Ес. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтны хариуцлага

9.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий инженер, эдийн засагч, борлуулалтын менежер, ерөнхий нягтлан бодогч зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтанд тооцно.

9.2. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтан нь үйлдвэрийн газрын дүрэм удирдах зөвлөлийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, үйлдвэрийн газрын ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

9.3. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, түүний хэм хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, үйлдвэрийн газрын дотоод журмаар тогтоож, шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.4. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтан санаатайгаар өөрийн хууль бус үйл ажиллагаанаас үйлдвэрийн газарт учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

Арав. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хяналтын тогтолцоо

10.1. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

10.1.1. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад Орон нутгийн өмчийн газар хяналт тавьж ажиллана.

10.1.2. Дотоодын хяналтыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

10.1.3. Хөндлөнгийн хяналтыг холбогдох хуулийн дагуу мэргэшсэн аудитын байгууллага гүйцэтгэнэ. Хөндлөнгийн аудитын тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж дүгнэлт гаргана.

Арван нэг. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэл, тайлан

11.1. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт

гаргуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал хариуцна.

11.2. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь санхүүгийн жил эхлэх хугацааг тухайн оны 01 дүгээр сарын 01-ээс, дуусах хугацааг мөн оны 12 дугаар сарын 31-ээр тогтооно.

11.3. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана. Үүнд:

11.3.1. Санхүүгийн байдлын тайлан

11.3.2. Орлого үр дүнгийн тайлан

11.3.3. Мөнгөн гүйлгээний тайлан

11.3.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан

11.3.5 Нэмэлт тайлбар, тодруулга

11.3.6. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үр дүнгийн хамт

Арван хоёр. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах

12.1. "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь дараах бичиг баримтыг хадгална. Үүнд:

12.1.1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, үйлдвэрийн газрыг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, үйлдвэрийн газрын бүртгэлийн болон газрын гэрчилгээ

12.1.2 Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх байгууллагаас баталсан үйлдвэрийн газрын дотоод бичиг баримт

12.1.3. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт

12.1.4. Инженерийн шугам сүлжээний байршлын зураг, тоног төхөөрөмжийн технологи ашиглалтын заавар, паспорт, техник тоног төхөөрөмжийн бүртгэлтэй холбоотой бусад бичиг баримт, материал

12.1.5 ТУЗ-ийн болон гүйцэтгэх байгууллагын хурлын тэмдэглэл шийдвэр, үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлын тушаал, гэрээ түүний биелэлтийн бичиг баримт

12.1.6. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт материалууд

12.1.7 Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлтийг байнга хадгална. Бусад бичиг баримтыг албан бичиг хадгалах хугацааны дагуу хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа архивд шилжүүлнэ.

Арван гурав. Сонирхлын зөрчил

13.1 "СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь Монгол Улсын аж ахуйн салбарын болон бусад байгууллага, аль нэг төрийн захиргааны байгууллагын санхүү удирдлагын сонирхлыг илэрхийлэхгүй болно.

Арван дөрөв. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг татан буулгах, ер төлбөрийг барагдуулах

14.1. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг Иргэний тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан үндэслэлээр, үүсгэн байгуулагчийн шийдвэрээр татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

14.2. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ер төлбөр барагдуулна.

Арван тав. Дүрэм хүчин төгөлдөр болох

15.1. “Солонго дулааны станц” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын энэхүү дүрэм нь батлагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

15.2. Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын Компанийн тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

15.3 Энэ дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг санал болгосноор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлүүлнэ.

--- оОо ---



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 06

Есөнбулаг сум

Аймгийн аварга тэмээчин шалгаруулж,
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр батлагдсан "Болзол батлах тухай" 88 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт амжилттай ажиллан, тэмээн сүргийн тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлэх уралдааны болзлыг дүгнэж Төгрөг сумын тэмээчин Ванчингийн Ням-Осорыг шалгаруулж шагнасугай.

2. Тэмээчин В.Ням-Осорыг "Аймгийн аварга малчин"-аар шагнаж, ажлын арга туршлагыг олон нийтэд сурталчилан таниулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Эрдэнэ-Очир/ нарт даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



0000018



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 07

Есөнбулаг сум

Аймгийн аварга үхэрчин шалгаруулж,
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр батлагдсан "Болзол батлах тухай" 87 дугаар тогтоол, Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт амжилттай ажиллан, үхэр сүргийн тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлэх уралдааны болзлыг дүгнэж Цээл сумын үхэрчин Охины Мөнхзулыг шалгаруулж шагнасугай.

2. Үхэрчин О.Мөнхзулыг "Аймгийн аварга малчин"-аар шагнаж, ажлын арга туршлагыг олон нийтэд сурталчилан таниулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Эрдэнэ-Очир/ нарт даалгасугай.



ДАРГА *[Signature]* П.БАТЖАРГАЛ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 09

Есөнбулаг сум

Аймгийн Тэргүүний хамт олон
шалгаруулж шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 113 дугаар тогтоолын 2.8 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөлмөрийн өндөр амжилт гарган, ажлын амжилтаараа тэргүүлсэн Олон нийтийн "Алтай радио", Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэг, Татварын хэлтсийг 2018 оны "Аймгийн тэргүүний хамт олон"-оор шалгаруулж шагнасугай.

2. Аймгийн тэргүүний хамт олноор шалгарсан байгууллагуудыг шагнаж, ажлын амжилт, арга туршлагыг олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



0000035



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 10

Есөнбулаг сум

Аймгийн хөдөлмөрийн аваргууд
шалгаруулж, шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 113 дугаар тогтоолын 2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөлмөрийн өндөр амжилт гарган, ажлын амжилтаараа салбартаа тэргүүлэн хамт олноо манлайлан ажилласан хавсралтад дурдсан нэр бүхий 9 хүнийг 2018 оны “Аймгийн хөдөлмөрийн аварга”-аар шалгаруулж, шагнасугай.

2. Аймгийн хөдөлмөрийн аваргаар шалгарсан дээрх хүмүүсийг шагнаж, ажлын амжилт, арга туршлагыг олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.


ДАРГА



Л.БАТЖАРГАЛ

0000026

Аймгийн ИТХ-ын Төргүүлэгчдийн
 2019 оны 01 дүгээр сарын 23-ны
 өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



АЙМГИЙН 2018 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АВАРГУУД

№	Овог нэр	Эрхэлдэг ажил, албан тушаал	Хамаарах салбар
1	Ухнаа Энхтуяа	Есөнбулаг сумын Улсын тэргүүний, үндэсний лаборатори 1 дүгээр сургуулийн сургалтын менежер	Боловсрол
2	Ядамцоо Сувдмаа	Аймаг дахь "Тогооч нарын холбоо"-ны салбар зөвлөлийн дарга	Худалдаа, нийтийн хоол
3	Ложоо Батгэрэл	Автотээврийн хяналтын улсын байцаагч	Зам тээвэр
4	Улаанбаатар Насанбат	Илий маллагч	Байгаль орчин
5	Баянмөнх Батсайхан	Цагдаагийн газрын Замын цагдаагийн зохицуулагч цагдаа, Цагдаагийн ахлах ахлагч	Хууль сахиулах
6	Балт Мянганбаяр	Бигэр сумын ЗДТГ-ын Бэлчээр, газар тариалан, хоршоо, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Хөдөө аж ахуй
7	Бадраа Элбэгжаргал	ЗДТГ-ын Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	Төрийн захиргаа
8	Арнаа Энх-Амгалан	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч	Байгаль орчин
9	Мухар Энхсүлд	Засварын монтер, байцаагч	Дэд бүтэц /эрчим хүч/



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 11

Есөнбулаг сум

“Уяач тэмээчин” шалгаруулж шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 113 дугаар тогтоолын 2.16 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тэмээн сүргийн ашиг шимийг нэмэгдүүлэх, тоо толгойг өсгөх, уналга эдэлгээнд сургах, аймаг бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож тодорхой амжилт гаргасан Эрдэнэ сумын тэмээчин Цэдэнхүүгийн Болдсайхан, Цээл сумын тэмээчин Лхагваагийн Хадбаатар нарыг аймгийн “Уяач тэмээчин”-ээр шалгаруулж шагнасугай.

2. Тэмээчин Цэдэнхүүгийн Болдсайхан, Лхагваагийн Хадбаатар нарыг шагнаж, ажлын амжилт, арга туршлагыг олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



0000033

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 0 дүгээр
сарын 2-ны өдрийн хурлаар батлав



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИТХ, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2019 ОНД ХИЙХ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилт:

1. Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй- төрийн үйлчилгээний жил” болгосонтой уялдуулан үйл ажиллагаагаа иргэдэд чиглүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.
2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгч, Хороодын Хурлын ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх, тэдний үүрэг хариуцлагыг дээшлүүлэн Хурлын чадавхийг бэхжүүлэх;
3. Шийдвэр гаргахад иргэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, төсөв болон иргэдийн амьдрал, ашиг сонирхолд нөлөөлөх асуудлыг иргэдээр хэлэлцүүлэн, тэдний саналыг тусган шийдвэрлэх;
4. Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс тавих хяналтыг сайжруулах
5. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс гаргасан хөтөлбөр, шийдвэрийг иргэдэд сурталчлан мэдээлэх ажлыг тогтмолжуулах

Д/д	Хийх ажлын утга	Хугацаа	Хариуцаж гүйцэтгэх байгууллага, албан тушаалтан
Нэг. Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалт, хурлын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлууд			
1	1.1	Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт	II улиралд Аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Аудитын газар ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
2	1.2	2019 оны төсөв тодотгол	II улиралд Аймгийн ЗДТГ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
3	1.3	Аймгийн ИТХ-ын хуралдааны дэгд өөрчлөлт оруулах тухай	II улиралд Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн

				Ажлын алба, Ажлын хэсэг
4	1.4	Аймгийн 2020 оны төсвийн тухай	IV улирал	Аймгийн Засаг дарга Санхүү төрийн сангийн хэлтэс
5	1.5	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны үйл ажиллагааны тайлан	IV улирал	Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын алба
6	1.6	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	IV улирал	Аймгийн ЗДТГ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
7	1.7	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	IV улирал	Аймгийн ЗДТГ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
8	1.8	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	IV улирал	Аймгийн ЗДТГ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
9	1.9	Иргэдэд 2020 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт батлах тухай	IV улирал	Аймгийн ЗДТГ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
Хоёр. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хурлын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлууд				
10	2.1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл байгуулах тухай	I улирал	Аймгийн ИТХ-ын ажлын алба Цагдаагийн газар
11	2.2	"Аймгийн аварга малчин, аварга фермер, аварга тариаланч" шалгаруулах	I улирал	Аймгийн Засаг дарга Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс Хүнс, хөдөө аж ахуйн газар
12	2.3	Тэмээн сүрэг өсгөж, ашиг шимийг нэмэгдүүлэх уралдааны болзлыг дүгнэж, аймгийн аварга тэмээчин шалгаруулах	I улирал	Хүнс, хөдөө аж ахуйн газар
13	2.4	Үхэр сүрэг өсгөж, ашиг шимийг нэмэгдүүлэх уралдааны болзлыг дүгнэж, аймгийн аварга үхэрчин шалгаруулах	I улирал	Хүнс, хөдөө аж ахуйн газар
14	2.5	Аймгийн Тэргүүний хоршоо шалгаруулах журмыг дүгнэж, шалгаруулж, шагнах	I улирал	Хүнс, хөдөө аж ахуйн газар
15	2.6	Аймгийн Тэргүүний хамт олон, хөдөлмөрийн аваргыг шалгаруулах асуудлыг хэлэлцэн батална	I улирал	Аймгийн ЗДТГ Төрийн захиргааны удирдлагын

				хэлтэс
16	2.7	2019 оны худалдах хөрөнгийн жагсаалт батална	I улирал	ОНӨГазрын дарга, мэргэжилтнүүд, ТУЗ, ААТҮГазрууд
17	2.8	Авлигын эсрэг дэд хөтөлбөр батална	I улирал	Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар
18	2.9	Хөрөнгө акталж данснаас хасахыг зөвшөөрөх тухай	I улирал	Орон нутгийн өмчийн газар
19	2.10	Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг батлуулах тухай	I улирал	ОНӨГазрын дарга, мэргэжилтнүүд
20	2.11	“Бид оролцъё-Хамтдаа хөгжъё” хөтөлбөрийн төслийг хэлэлцэн батлах тухай	I улирал	Нийгмийн бодлогын хэлтэс Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
21	2.12	Сахилга хариуцлагын жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийн тухай	I улирал	Аймгийн ЗДТГ Хууль эрх зүйн хэлтэс
22	2.13	2019 оныг нэрэмжит жил болгох тухай	I улирал	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн ажлын алба
23	2.14	“Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн төслийг хэлэлцэн батлах тухай	I улирал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс Хүнс, хөдөө аж ахуйн газар
24	2.15	Аймгийн дэд хөтөлбөрүүдийн биелэлт	1-2-р улирал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд
25	2.16	ОНӨААТҮГазруудын үйл ажиллагааны тайланг танилцуулах, 2019 оны хувьчлах хөрөнгийн жагсаалт батлуулах тухай	I улирал	Орон нутгийн өмчийн газар ТУЗ, ОНӨААТҮГ
26	2.17	“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах	I улиралд	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, ХХААГ
27	2.18	Солонго дулааны станц ААТҮГазар байгуулах	I улиралд	Орон нутгийн өмчийн газар
28	2.19	Аймгийн өмчийн нэгдсэн тайланг хэлэлцүүлэх тухай	II улирал	Орон нутгийн өмчийн газар
29	2.20	ОНӨ-ийн эзэмшилт, ашиглалтын хагас, бүтэн жилийн мэдээлэл, тайланг хэлэлцэх	Хагас, бүтэн жилээр	Орон нутгийн өмчийн газар
30	2.21	Цэргийн дүйцүүлэх албыг 2019 онд биеэр хаах иргэдийн тооны хязгаарыг батлах тухай	II улирал	Цэргийн штаб хурандаа

31	2.22	Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлах тухай /Алтай, Баян-Уул, Бигэр, Тонхил сум/ 3 хувааж оруулах	II улирал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
32	2.23	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх” аймгийн дэд хөтөлбөр батлана.	I улирал	Нийгмийн бодлогын хэлтэс Эрүүл мэндийн газар
33	2.24	“Гэр бүлийн үнэ цэнэ” аймгийн дэд хөтөлбөр батлана.	I улирал	Нийгмийн бодлогын хэлтэс Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
34	2.25	Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх эхний үе шатны хэрэгжилтийн тайланг хэлэлцэх	II улирал	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
35	2.26	“Говийн гайхамшигт-6” хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэн батлах тухай	II улирал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс Байгаль орчин, аялал жуулчлалын газар
36	2.27	Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн биелэлт	II улирал	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба Татварын хэлтэс
37	2.28	Халиун, Жаргалан, Есөнбулаг сумдын ойн цэвэрлэгээний хуваарь	II улирал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс Сум дундын ойн анги
38	2.29	Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулж буй ажлын явц үр дүнгийн тухай цагдаагийн байгууллагын даргын мэдээллийг хэлэлцэн үүрэг чиглэл өгч биелэлт, үр дүнг тооцох	II, IV улирал	Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар
39	2.30	Аймгийн ИТХ-ын 78 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дагуу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээлийн тухай асуудлыг хэлэлцүүлэх	I,III улиралд	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
40	2.31	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээллийг хэлэлцэн үүрэг чиглэл өгч биелэлт үр дүнг тооцох	II, IV улирал	Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар

41	2.32	НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийн талаар ИТХ-ын Тэргүүлэгчид мэдээлэл сонсох	II улирал	Татварын хэлтэс
41	2.33	Аймгийн өмчийн нэгдсэн тайлан гаргаж, дүнг батлуулах тухай	II улирал	ОНӨГазрын дарга, мэргэжилтнүүд
42	2.34	ОНӨААТҮГазруудын үйл ажиллагааны тайлантай танилцах 2019 оны төлөвлөгөөг батлах	II улирал	ОНӨГазрын дарга, мэргэжилтнүүд, ТУЗ, ОНӨААТҮГазрууд
43	2.35	Үүлэнд зориутаар нөлөөлж хур тунадас оруулах асуудлыг дэмжиж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана	4-5-р сард	ИТХ-ын Тэргүүлэгчид Ажлын алба УЦУОШГазар
44	2.36	Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баарангийн давааны болон Дэлгэр сум дахь замын цагдаагийн постуудад үүрэг гүйцэтгэх 4 олон нийтийн цагдаагийн урамшуулал, хөдөлмөр хамгааллын хувцас, тусгай хэрэгслийн зардлын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх	II улиралд	Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар
45	2.37	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэх хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг тогтоож, холбогдох зардлын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх	II улиралд	Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар
46	2.38	"Архигүй-Алтайчууд" хөтөлбөрийн хэрэгжилтийг авч хэлэлцэнэ	III улиралд	Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар
47	2.39	"Иргэдээс гэмт хэргийн талаар төлбөртэй мэдээлэл авах тухай журам" батлана	II улиралд	ИТХТ-ийн ажлын алба Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар
48	2.40	Хяналт шалгалт тавьж ажилласан ажлуудыг үр дүнг авч хэлэлцэж шийдвэрлэх	Тухай бүр	ИТХ, Тэргүүлэгчид
49	2.41	Аймгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг цаг хугацаа харгалзахгүйгээр аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлэж ажиллах	Тухай бүр	ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид ЗДТГ ИТХТ-ийн ажлын алба

Гурав. Хяналт, шалгалт олон нийттэй харилцах талаар үйл ажиллагааны талаар				
46	3.1	Худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг хэлэлцэж ажиллана.	Эхний улиралд	Тэргүүлэгчид, хороод
47	3.2	Шинээр ашиглалтад орсон төрөх эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, 2018 оны 12 сарын 31-нээс 2019 оны 01-р сарын 01-нд төрсөн эхчүүдэд хүндэтгэл үзүүлнэ	1-р сард	ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид ажлын алба
48	3.3	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт хийх	II улирал	Тэргүүлэгчид, хороод
49	3.4	Иргэдээс ИТХ, Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэх асуудлаар санал асуулга авч ажиллах	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
50	3.5	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлтийн байдалд хяналт тавьж, үр өгөөжийг сайжруулах	III улирал	Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогын хороо Санхүүгийн хяналт, аудитын алба
51	3.6	Аймаг сумдын албан байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавих	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчид Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба
52	3.7	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлт, зээл олгоход мөрддөг журмын хэрэгжилт ямар түвшинд байгаад хяналт шалгалтын ажил зохион байгуулах	Жилдээ	Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогын хороо Санхүүгийн хяналт, аудитын алба
53	3.8	Хүнсний аюулгүй байдлын талаар МХГ-ын мэдээлэл сонсож, зарим үйлдвэр үйлчилгээний газруудад хяналт тавьж ажиллах	1-р улиралд	Тэргүүлэгчид, хороод ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
54	3.9	"Аймгийн нутаг дэвсгэрт мал, мах худалдан борлуулахад тавигдах шаардлага, түүнд хяналт тавих журам" батлана.	I улиралд	ИТХ-ын Тэргүүлэгчид Мэргэжлийн хяналтын газар
55	3.10	2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих	Жилдээ	Тэргүүлэгчид, хороод
56	3.11	ИТХ, Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийг 14 хоног тутам иргэд, олон нийтэд мэдээлэх	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба

Дөрөв. Сургалт, семинарын зохион байгуулалт, мэдээлэл сурталчилгаа, гадаад харилцааны үйл ажиллагааны төлөвлөгөө				
57	4.1	Сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын нэгдсэн сургалт зохион байгуулна	1-р улиралд	ИТХ-ын дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
58	4.2	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг Удирдлагын Академийн сургалтад хамруулна	2-р сард	ИТХ-ын дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
59	4.3	Байгууллагын албан хаагч, мэргэжилтэнүүдэд архивын сургалт авч ажиллана	3-р сард	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба Архивийн тасаг
60	4.4	БНХАУ-ын Шинжан-Уйгарын өөртөө засах орны Хами аймаг, Ганьсу мужтай гадаад харилцаагаа өргөжүүлж, туршлага солилцож хамтран ажиллах	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
61	4.5	Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр Архивын ерөнхий газрын сургалтад бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнг оролцуулна	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
62	4.6	Төрийн албан хаагчийн манлайлах ур чадвар сургалтанд ажлын албаны төрийн албан хаагчидаа хамруулж сургана.	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
63	4.7	Баруун бүсийн аймгуудын сонгуультан, ажилтнуудын туршлага судлах арга хэмжээ /Ховд аймагт/	2-р улиралд	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
64	4.8	Сумдын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, дотуур байрны багш, жижүүрүүдийг хамруулсан сургалт семинар зохион байгуулна	3-4-р сард	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба ГХУСА33 Аймгийн БСГазар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
65	4.9	960 хүүхэдтэй шинээр ашиглалтад орох 4-р сургуулийн үйл ажиллагаатай танилцаж ажиллах	I-II улирал	ИТХ-ын Тэргүүлэгчид
Тав: ГХУССА33-ийн ажил болон бусад ажлын талаар:				
66	5.1	Согтууруулах ундааны хортой хэрэглээ, осол гэмтэл, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагавраас нийгмийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хамгаалах талаар эрүүл мэнд хууль хяналтын байгууллагын хамтарсан зөвлөгөөн, сургалт зохион байгуулах	I улирал	Аймгийн ГХУСА33эвлөл Эрүүл мэндийн газар
67	5.2	Өсвөр насны хөвгүүдийг болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний нийгмийн	I улирал	Боловсрол соёлын газар Гэр бүл, хүүхэд, залуучуудын

		идэвх оролцоог нэмэгдүүлж, хорт зуршлаас татгалзан биеэ зөв авч явах ёс суртахууны зөв зан үйлийг төлөвшүүлэхэд нь дэмжих, цахим ертөнцөд учирч болох эрсдлээс өөрсдийгөө болон найз нөхдийгөө хамгаалах мэдлэг мэдээллээр хангах, тэдний хүмүүжил төлөвшлийг сайжруулах зорилгоор “Эрхэм сайн хөвгүүн” аянг зохион байгуулах		хөгжлийн газар
68	5.3	Хүүхдийн эрхийн зөрчил, илрүүлэлт, хяналт шалгалтын ажлыг сумдад зохион байгуулах	II улирал	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
69	5.4	Тухайн улирал, жилд зохиосон ажлын тайлан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	2, 4, 9, 12-р сар	ГХУСАА33 Цагдаагийн газар
70	5.5	2019 оны гэмт хэрэг, зөрчлийн талаарх танилцуулга, мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээ, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад авах арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл сонсох	IV улирал	Цагдаагийн газар
71	5.6	Хил залгаа аймгуудын ГХУСА33-тэй хамтран Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр туршлага солилцож зөвлөгөөн зохион байгуулах	II улирал	Цагдаагийн газар
72	5.7	Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулна.	Жилдээ	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс
73	5.8	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр насанд хүрээгүй хүүхдүүдийн дунд хичээлээс гадуур төрөл бүрийн ажил, /цуврал хичээл, уулзалт, ярилцлага, мэтгэлцээн, ханын сонин, зурагт хуудасны уралдаан зарлах	Жилдээ	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар ТББ
74	5.9	Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах зорилгоор “Бүх нийтийн эргүүл”, “Урамшуулалт эргүүл”, “Хариуцлагатай эргүүл” ажиллуулах	Жилдээ	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар, ТББ

		арга хэмжээг зохион байгуулах		
75	5.10	"Хүний эрх ба ёс зүйн хариуцлага" сэдэвт сургалтуудыг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах	III улирал	Цагдаагийн газар Мэргэжлийн хяналтын газар Байгаль орчин аялал жуулчлалын газар
76	5.11	Мал хулгайлах, хууль бус ан, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг тухайн гэмт хэрэг гарсан орон нутагт шүүх хуралдааныг иргэдийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлэх	Тухай бүр	Прокурорын газар Цагдаагийн газар
77	5.12	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн хууль тогтоомж, байгаль экологийн ач холбогдол, экологи эдийн засгийн нөхөн төлбөрийн талаар иргэдэд сурталчлах	Жилдээ	Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар Байгаль орчин аялал жуулчлалын газар
78	5.13	Гэмт хэрэг захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр телевизийн шторк, мэдээ, мэдээллийг бэлтгэж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	II, III улирал	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар, ТББ
79	5.14	Авлигатай тэмцэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	III, IV улирал	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс
80	5.15	"Ногоон гэрэл-Цагаан шугам" тэмцээнийг сумдад бүсчлэн зохион байгуулах	III улирал	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс
81	5.16	Аймгийн хууль хяналтын холбогдох байгууллагуудтай хамтран сумдын ГХУСАЗСЗ-ийн ажлыг шалган туслах ажлын хэсэг ажиллуулна	II, IV улирал	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар
82	5.17	Архи согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж шаардлагатай бол тусгай зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох	Жилдээ	Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар Мэргэжлийн хяналтын газар
83	5.18	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, ялангуяа газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан шалгалт, ажиллагааг зохион	Жилдээ	ГХУСАА33 Байгаль орчин аялал жуулчлалын газар Мэргэжлийн хяналтын газар

		арга хэмжээг зохион байгуулах		
75	5.10	"Хүний эрх ба ёс зүйн хариуцлага" сэдэвт сургалтуудыг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах	III улирал	Цагдаагийн газар Мэргэжлийн хяналтын газар Байгаль орчин аялал жуулчлалын газар
76	5.11	Мал хулгайлах, хууль бус ан, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг тухайн гэмт хэрэг гарсан орон нутагт шүүх хуралдааныг иргэдийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлэх	Тухай бүр	Прокурорын газар Цагдаагийн газар
77	5.12	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн хууль тогтоомж, байгаль экологийн ач холбогдол, экологи эдийн засгийн нөхөн төлбөрийн талаар иргэдэд сурталчлах	Жилдээ	Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар Байгаль орчин аялал жуулчлалын газар
78	5.13	Гэмт хэрэг захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр телевизийн шторк, мэдээ, мэдээллийг бэлтгэж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	II, III улирал	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар, ТББ
79	5.14	Авлигатай тэмцэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	III, IV улирал	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс
80	5.15	"Ногоон гэрэл-Цагаан шугам" тэмцээнийг сумдад бүсчлэн зохион байгуулах	III улирал	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс
81	5.16	Аймгийн хууль хяналтын холбогдох байгууллагуудтай хамтран сумдын ГХУСАЗСЗ-ийн ажлыг шалган туслах ажлын хэсэг ажиллуулна	II, IV улирал	Аймгийн ГХУСАА33 Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар
82	5.17	Архи согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж шаардлагатай бол тусгай зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох	Жилдээ	Хууль эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар Мэргэжлийн хяналтын газар
83	5.18	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, ялангуяа газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан шалгалт, ажиллагааг зохион	Жилдээ	ГХУСАА33 Байгаль орчин аялал жуулчлалын газар Мэргэжлийн хяналтын газар

		байгуулж үр дүнг тооцон ажиллах		
84	5.19	Сумдын ИТХ, Тэргүүлэгчдийн ажлыг албыг мэргэжил арга зүйгээр хангаж, сумдад ажиллах	1-р улиралд	ИТХ-ын Тэргүүлэгчид, ИТХТ-ийн ажлын алба
85	5.20	Сумдын ИТХ, Тэргүүлэгчдийн ажлын албаны үйл ажиллагааны мэдээ тайланд дүн шинжилгээ хийж, сумдын ажлыг дүгнэж шагнаж урамшуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчид, ИТХТ-ийн ажлын алба
86	5.21	Нийтийн сонсгол зохион байгуулна. / Хөдөөгийн 1-2 сумд/	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчид, ИТХТ-ийн ажлын алба
87	5.22	Архивын улсын үзлэг угтаж, архивын нэгдсэн сан программтай болох	Хагас жилд	ИТХТ-ийн ажлын алба
88	5.23	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаж, төсвийн үр ашигтай зарцуулж аудитын стандарт үнэлгээ авахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.	Жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчид, ИТХТ-ийн ажлын алба
Зургаа: Иргэний танхимаар хэлэлцүүлэх асуудлын талаар:				
89	6.1	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хэлэлцүүлэг зохион байгуулна	I улиралд	ИТХ-ын Тэргүүлэгчид, хороод ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба
90	6.2	Архи-Алтай" хөтөлбөрийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулна. /Аймгийн ГХУСА33-тэй хамтран/	I улиралд	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба ГХУСА33
91	6.3	Аймагт Дулааны станц байгуулах талаар хэлэлцүүлэг холбогдох байгууллагатай зохион байгуулна.	I улиралд	ЗДТГ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс ИТХТ-ийн ажлын алба
92	6.4	"Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах.	I улиралд	Хууль эрх зүйн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,
93	6.5	Хүүхдийн эсрэг гэмт хэргийн талаарх мэдээлэл солилцох хэлэлцүүлэг сургалт зохион байгуулна.	3-4-р сард	ИТХТ-ийн ажлын алба ГХУСА33, БСГазар

				Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
94	6.6	Осол гэмтлээс сэргийлэх талаар мэдээлэл, хэлэлцүүлэг хийх	II улирал	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба Нийгмийн бодлогын хэлтэс Эрүүл мэндийн газар
95	6.7	“Бид оролцъё-Хамтдаа хөгжъё” хөтөлбөрийг хэлэлцүүлэх	I улирал	Нийгмийн бодлогын хэлтэс Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
96	6.8	Улсын Их хурлын Тамгын газар болон харъяа яамдаас ирүүлсэн хууль тогтоомжийн төслөөр иргэд олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулж саналыг холбогдох газарт хүргүүлэх	Тухай бүр	ИТХ-ын ажлын алба Хууль эрх зүйн хэлтэс
97	6.9	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж хэлэлцүүлэх	I улирал	ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба Нийгмийн бодлогын хэлтэс Эрүүл мэндийн газар

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
АЖЛЫН АЛБА**